

ОЙЛГОХ НЬ ОРЧУУЛАХЫН АМИН СҮНС

С.Эрдэнэмаам* (МУБИС)

Нэрт эрдэмтэн Ц.Дамдинсүрэн гуай “Шүлгийг орчуулах гэгч үг, утгыг орчуулах төдий биш, түүний найруулгын хэв журам ба уран хэл, сэтгэлийг хөдөлгөх чадлыг бүрнээ орчуулах хэрэгтэй” хэмээн “Олег цэцний орчуулгын тайлбар”-таа бичиж байжээ¹⁶². Тэрээр цааш нь сургахдаа аливаа зохиолыг орчуулах үед “...үгийг нэмж хасах гайгүй хэрэг, утгыг нэмж хасвал гэмтэй хэрэг. ... Нэг талаас үгийг хэтэрхий баримталбал утгыг алдана. Бас нөгөө талаас үгийг хайхрахгүй ахул уг эхээс хэтэрхий холдож орчуулга гэж таньшгүй болно”¹⁶³ гэсэн байна. Мэргэн гүүшийн сургаал өнөө хэр үнэ цэнээ алдаагүй байгаа нь орос хэлнээс орчуулсан яруу найргийн хийгээд үргэлжилсэн үгийн зарим зохиолоос харагдаж байна.

Бид эл бяцхан өгүүлэлдээ яруу найргийн орчуулгыг С.Есениний шүлгийн орчуулга, үргэлжилсэн үгийн зохиолынхыг А.Чеховын өгүүллэгүүдийн орчуулгын жишээн дээр нягтлан үзэж, санаа бодлоо уншигчидтай хуваалцахаар зорьсон бөлгөө.

С.Есениний уран бүтээлээс Э.Оюун, Б.Явуухулан, М.Цэдэндорж, С.Баясгалан нарын зэрэг томчууд орчуулан гаргасан байдаг. Харин орчуулагч Ж.Нэргүй гурван жилийн өмнө “Сергей Есенин. Сонгомол шүлгүүд” гэдэг номыг хэвлүүлжээ. Сөхөн үзвэл, профессор С.Баясгалан абугай “Өчихийн учир” гэсэн өмнөтгөл бичиж “... нэгэн биед бурханаас заяасан даанч олон онгодтой нэрт сэтгүүлч, яруу найрагч, бас алдаршиж яваа дуун хөрвүүлэгч” хэмээн Ж.Нэргүйг магтжээ. Мөн “Яруу найрагчтай нь өрсөлдөх болно” гэсэн нэр бүхий өмнөх үгдээ монголч эрдэмтэн Ю.Кручкин түүнийг “... ийм их гавьяа байгуулж буй Нэргүй орчуулагч Монголд хамгийн нэртэй гүүш болж байгаад нь чин сэтгэлээсээ баярлаж, тэнгэрлэг бүтээлд нь их амжилт хүсье” гэсэн байв. Мөн яруу найрагч Ц.Жамбалгарав “Есениний хөргийг 30 жил ширтэж суугаад...” хэмээх өмнөтгөлдөө “... уяраан догдлуулсан гайхамшигт яруу шүлэг, мөр бадгуудыг дэндүү сайхнаар монгол хүний сэтгэлд буулгаж чадсан нь өөрийн эрхгүй бахархал төрүүлнэм” гэж уулгалсан байна. Эдгээр өмнөтгөлөөс үзэхүл Есениний шүлгүүдийг Ж.Нэргүй үнэхээр сайн орчуулсан юм байна гэсэн сэтгэгдэл төрснийг нуух юун. Сайхан сайхан онож хэлсэн, эгээ л монгол шүлэг лугаа болсон орчуулга хэд хэд байна. Гэвч өмнөх үг бичсэн мэргэд орчуулагчийг хангалттай магтсан байгаа учраас энд эндүүрсэн ташаарсан зарим зүйлийн талаар өгүүлье. Орчуулгын гэлтгүй ер

*МУБИС-ийн ГХС-ийн орос хэл, уран зохиолын тэнхмийн эрхлэгч, профессор, доктор

¹⁶²Ц.Дамдинсүрэн. Монгол хэл бичгийн тухай. Улаанбаатар, 1957. 10-р тал.

¹⁶³Мөн тэнд, 15-р тал.

аливаа шүүмж үнэнийг өгүүлсэн, цаашид алдаа мадаг гаргахаас сэрэмжлүүлсэн байдгаараа зохиолч, орчуулагчдын сэтгэлд нэг их таалагддаггүй буй заа. Ийм ч учраас сүүлийн үед орчуулгын үнэн зөв, шударга шүүмж гарах нь нэн ховор болжээ. Гэтэл эндүүрч ташаарсныг нь шударгаар хэлж өгөхийн оронд хий хоосон, тэнгэрт тултал магтаад байх нь гадаадын уран зохиолоос ард түмэндээ дээжлэн таниулдаг орчуулгын ажлын чанарт муу нөлөөтэйг бодох цаг болсон мэт санагдана. Одоо зарим шүлгийн орчуулгыг сонирхоё.

Поёт зима – аукает,

Мохнатый лес баюкает

Стозвоном сосняка.

Кругом с тоской глубокою

Плывут в страну далёкую

Седые облака.

Энэ хэсэгт шүлгийн мөрд буй үгийн тоог хадгалж, толгой сүүл холбосон нь сайшаалтай ч, “аукает” гэснийг “гуугална”, “баюкает” гэснийг “хүүглэнэ” гэж орчуулсны зэрэгцээ зөвхөн сүүл холбохын тулд “умбарна”, “шуударна” гэсэн үйл үгүүдийг нэмжээ:

Дуучин өвөл гуугална.

Дуулган ой хүүглэнэ.

Нарсан төгөл шуугина.

Бөөн уйтгарт умбана.

Бөмбийх үүлс умбарна.

Бертийх алс руу шуударна.

“Гуугална” гэхлээр хэрээ шувуу л юуны өмнө санаанд бууж байна. “Дуулган ой” гэдэг хэр оновчтой зүйрлэл бол? Оросоор “мохнатый лес” гэсэн нь “сүглэгэр ой” гэсэн санаа байх шиг. “Умбарна” гэдэг үгийг ер ойлгосонгүй, толь бичгээс ч хайгаад олсонгүй, монгол хэл судлаач эрдэмтэн мэргэдээс асуухад мэдэхгүй гэлцэх юм. “Умба” гэдэг үйл үгийг толь бичгээс шүүрдэж үзвэл “алтанд умбах”, “жаргалд умбах”, “торгонд умбах”, “тосонд умбах”, “магтаалд умбах” гэх зэргээр эерэг утгаар хэрэглэсэн нь олонтаа бөгөөд “уйтгарт умбах” гэхчлэн сөрөг утгатай жишээ баримт алга. Ц.Дамдинсүрэн гуай дээр дурьдсан өгүүлэлдээ “Үг ба өгүүлбэрт халдаж болно. Гол утгад халдаж болохгүй” гэж сургасан, гэтэл орчуулгын энэ хэсэгт аль алинд нь халджээ. Өөрөөр хэлбэл, үг, өгүүлбэрт хэтэрхий халдан утгыг айхавтар гажуудуулснаар өвлийг “гуугалуулж”, үүлсийг “умбаруулсан” байна.

Мөн шүлэгт:

А вьюга с ревом бешеным

Стучит по ставням свешенным

И злится все сильней гэснийг

Цонхны хавтас дэрчигнэнэ

Цасан шуурга тэлчигнэнэ

Цочмог цочмог ширүүснэ гэжээ.

Энд цонхны самбарыг хавтас гэж ташаарсны зэрэгцээ “цасан шуурга тэлчигнэнэ” гэсэн нь утгыг айхавтар гажуудуулсан байна. Я.Цэвэл гуайн “Монгол хэлний тайлбар толь”-д “тэлчигнэх”-ийг “тэлчлэх, тийчлэх” гэж тайлбарласнаас үзвэл хүн, амьтан хөлөө ийш тийш савлахыг хэлдэг бололтой. Энэ орчуулгыг уншсан хүүхэд багачууд “Гадаа цасан шуурга тэлчигнэж байна” гээд яриад эхэлбэл “чи буруу ярьлаа” хэмээн шүүмжилж болохгүй нь ээ.

“Русь” хэмээх бяцхан мөртлөө алдарт найраглалын агуулгыг орчуулагч ер ойлгоогүй бололтой. Түүхэн сэдэвт зохиол бүтээлийг орчуулахын тулд тухайн үеийн улс орны түүх, ард түмний аж амьдрал, ахуй соёлыг сайтар судлах шаардлагатай гэсэн орчуулгын онолын зарчим байдаг. Энэхүү найраглалыг орчуулахдаа орчуулагч маань тэгж өөрийгөө “зовоосонгүй” нь илт. Ингэдэггүй юмаа гэхэд түүнд байгаа түүхэн үг хэллэгийн утгыг өөрөө мэддэггүй бол толь бичгээс сайтар шүүрдэх хэрэгтэй байжээ. Найраглалын 4-р хэсгийн сүүлийн дөрвөн мөрийг хэрхэн “орчуулсан”-ыг сонирхоё.

Собралися на четницею Лушею

Допытаться любимых речей.

И на корточках плакали, слушая,

На успехи родных силачей.

Энэ бадгийг орчуулагч огт ойлгоогүй нь илт. “Четница Луша” гэдэг нь энэ найраглалд нэр цохон гарч байгаа цорын ганц баатар, фронтоос ирсэн захидлуудыг хүмүүст чангаар дуудан сонсгодог төдийгүй мэргэч, төлөгч бүсгүй юм. “Допытаться любимых речей” гэсэн нь “сайхан мэдээ сонсохоор” хүмүүс түүнийг зорьж ирдэг гэсэн санаа. Бадгийн агуулгыг ойлгоогүй учраас үүнийг:

Орой руу нь орох үгсийг бүгд сонсохоор ирцгээв.

Оточ Лушагийн модон эрхийг эргүүлэхээр ирцгээв.

Өвдөг бохирон суугаад гаслан гаслан уйлалдав.

Өрмөг сэтгэлт баатруудаа санан санан дуулалдав.

хэмээн “орчуулжээ”. Мэргэн гүүш Ц.Дамдинсүрэн гуай мөнөөх өгүүлэлдээ “... монгол хэлэнд хоршоо үг хэрэглэхэд их л нийлэмжтэй. Өшөө хорсгол, харгуй зам гэх мэт аливаа утгаар адилавартар хоёр үгийг хоршуулан нэг утга болгож хэрэглэх заншил бий. ... Энэ нь орос шүлгийн мөрөөс монгол шүлгийн мөрийн урт болох нэгэн шалтгаан болно” гэж сургасан байдаг. Орос эхийн мөр гурван үгтэй, орчуулгад даруй хоёр дахин өсч, зургаан үгтэй болсныг онолын энэхүү зарчмаар орчуулжээ гэж бодоод өршөөж болох. Гэтэл мэргэч төлөгч Луша бүсгүйг “Оточ Луша”, “сайхан мэдээ сонсохоор ирсэн хүмүүс”-ийг “Оточ Лушагийн модон эрхийг эргүүлэхээр ирцгээв” болгосныг өршөөж хараахан болохгүй мэт. “Четница” – мэргэч, төлөгч гэдэг үгийг “чётки” – эрхи гэдэг

үгтэй андуурснаас ийнхүү “Ихмэдэх .. хүйтэн индүү идэв” гэдэг шиг инээдэмтэй зүйл болжээ. Өмнөх үг хайрласан мэргэд энэ номыг уншилгүй “харанхуй” бичив үү, эсвэл уншсан ч “анзаарсангүй” юу?

Найраглалын энэ хэсгийн эхний бадгийн орчуулга үүнээс ч илүү инээдэмтэй, бүр эмгэнэлтэй болжээ:

Затомилась деревня невесточкой-

Как-то милые в дальнем краю?

Отчего не уведомят весточкой –

Не погибли ли в жарком бою?

“Невесточка” гэдэг нь “мэдээ ирэхгүй байх” гэсэн утгатай, “весточка” гэдэг үгний эсрэг утгатай үг юм. Гэтэл “бэр” хэмээн эндүүрснээс инээдэмтэй байдал үүсчээ. Мөн л “...хүйтэн индүү идүүлж”, эхний мөрийг:

Бэрүүдийн шаналан тосгон сууринг нөмрөв гэж “айлджээ”.

Энэ мэтийн сонин содон мөр бадаг их элбэг тааралдлаа. Тухайлбал, “Оюун ухааныг” юугаараа овсхийн бостол дуудна” /18-р тал/, “Шижи алтаар жингэнэх Шилмүүст модон ой” /29-р тал/, “Нэр чинь урьдын адил жингэнэхээ больжээ” /40-р тал/, “Гүлмэн саран алтан мэлхий шиг сэрүүн байгаа” /49-р тал/ гэх мэт. “Русь” найраглалыг бүхэлд нь авч үзвэл бадаг бүрд л энэ мэт андуурсан ташаарсан, орос эхийн агуулгыг үгт ойлгоогүй зүйл тааралдаж байна.

Эдгээр алдаа мадаг, өмнөх үгүүдэд буй магтаал хоорондоо нэг л авцалдахгүй байгаа нь орчуулагчийн болон түүний ариутган шүүгчдийн хэн хэнийх нь хариуцлага сул байгааг харуулж байна.

Үргэлжилсэн үгийн зохиолын орчуулгын тухайд гэвэл, Монгол улсын төрийн соёрхолт, ардын уран зохиолч Дөнгөтийн Цоодол аругай Оросын сонгодог зохиолч А.П.Чеховын шилдэг өгүүллэгүүдээс эх хэлнээ орчуулан “Бачтай хүмүүс” нэртэйгээр хэвлэн гаргажээ. Богино өгүүллэгийн их мастерын 70 гаруй бүтээлийг ийнхүү монгол уншигчдын хүртээл болгосон нь томоохон буян билээ. Дэлхий даяар сая сая хүн зуун дамжин амтархан уншиж, сэтгэлийн таашаал авсаар буй ийм их хүний тийм сайхан зохиол бүтээлийг мөн л үе үеэрээ шүтэн биширч, хүндэтгэн дээдэлж явдаг том зохиолч орчуулах ёстой юм байна гэсэн итгэл үнэмшил надад төрлөө. Учир юун хэмээвээс, чухамхүү зохиолч хүн л аливаа бүтээлийг гадаад хэлнээс орчуулахдаа эх хэлээрээ бичиж байгаа лугаа адил уран яруу найруулан бичих увдистай ажээ. Энд өгүүлэх гэж буй орчуулгад Конёв, Лошадинский, Кобылева гэх зэрэг орос нэрүүд байгаагүйсэн бол монгол зохиол гэж эндүүрэхээр, донсолгоогүй замаар ягуухан давхих мэт, уншихад амар, сайхан зохиол болжээ.

Бага байхдаа Н.Носов гэдэг хүний бичсэн “Үлмэдэх ба түүний нөхөд” хэмээх номыг уншаад монгол хүний зохиол гэж бат итгэдэг байж билээ. Одоо бодохноо баатруудынх нь нэрийг хүртэл Үлмэдэх, Ихмэдэх гэхчлэн орчуулсан учраас тэгж санагддаг байж. Дамдинсүрэн гуайн хөрвүүлсэн “Алтан загасны үлгэр” ч мөн л адил, орчуулгын гэж ер санагддаггүй шүү дээ. Сайн орчуулагчийн бүтээл ингэж л уншигчийг эзэмдэж, сэтгэл зүрхэнд нь хүрдэг ажгуу.

Д.Цоодол абугайн орчуулгад ч мөн нэгэн адил "... хоол унднаас гарав", "... архинд амиа тавина", "... тэрнийг Саратовын нохой нь ч андахгүй мэднэ", "... даанч хариугүй муу юм өгөх юм" гэх зэргээр эгээ л монгол зохиол уншиж байгаа юм шиг сэтгэгдэл төрүүлэхүйц найруулгаар орчуулсан нь элбэг тааралдаж байна.

"Бачтай хүмүүс"-ээс "Адууны овог" өгүүллэгийн тухайд онцлон цөөн зүйл хэлмээр санагдав. Энэ өгүүллэгт чөлөөнд гарсан нэгэн генералын шүд өвдөж, эмчид үзүүлээд ч тусыг эс олон зовж байгаа тухай, нэг барлаг нь шүдийг шившлэгээр эдгээдэг сайн хүн хажуугийн хошуунд бий, түүнд цахилгаан бичвэл алс холоос ч гэлээ ганцхан шившээд л эдгээчихнэ гэж зөвлөж, аргаа барсан генерал эхлээд дургүйцсэнээ түүнд цахилгаан бичихээр болж, овог нэрийг нь асуухад нөгөөх барлаг овгийг нь санахгүй, "За байз, адууны хавьцаа л овогтой хүн дээ" гэж хэлсэн, айл хотлоороо тийм овог зохиож, аль нь ч онохгүй будилж байгаа, хонон өнжин бодоод ч олж чадаагүй учир генерал шүдээ авахуулсны дараа л гайтай мөнөөх овгийг олж байгаа тухай тун инээдэмтэй явдлыг их л хөгжөөнтэй өгүүлжээ.

Буянтай үйл хийсэн буурал зохиолчийнхоо гавьяа зүтгэлийг өчүүхэн ч үл үгүйсгэн зарим нэгэн санаа бодлоо хуваалцахаар энэхүү зүйлийг чадан ядан тэрлэж байгаадаа юуны өмнө хүлцэл өчьюү. Ард олныг гадаад улс орны уран зохиолтой танилцуулж, оюун мэлмийг нь улам улам цэнэглэн гэгээрүүлэхэд үнэлж баршгүй тус болдог орчуулгын ажлын хойч ирээдүйд дэм болуужин гэж үүнийг бичиглэснийг минь оюунт мэргэд ойлгон болгоох буй заа.

"Адууны овог" гэсэн нэрнээсээ эхлээд бодох юм цөөнгүй мэт санагдав. "Адууны овог" /оросоороо "Лошадиная фамилия"/ гээд уншихад "Адуунд ямар овог байдаг билээ?" гэсэншүү бодол өөрийн эрхгүй орж ирж байна. Орчуулагч үүнийг ойлгоогүй биш, ойлгосон, яагаад гэвэл орчуулга дотор "... Тийм нэгэн маш энгийн, адууных ч гэмээр овог байсан юм сан" гэсэн өгүүлбэр байна. Тэхлээр яг адууны овог биш, харин адууны хавьцаа л үгийн тухай гэдгийг орчуулагч сайн мэдсэн хэрэг, гэвч гарчгийг оноохдоо сайтар тунгаасангүй юү дээ гэх бодол төрлөө. "Адууны хавьцаа овог", "Адуутай холбоотой овог" гэвэл арай ойртох байсан болов уу. Гарчиг угаасаа хоёр үгтэй учир хоёр үгээр л орчуулна гэж сэтгээгүй нь мэдээж. Дашрамд тэмдэглэхэд, сүүлийн үед гадаадын нэг үгийг нэг л үгээр орчуулна гэсэн бодол нэн ялангуяа манай их дээд сургуулийн багш, эрдэмтдийн дотор сүрхий хавтгайрах хандлагатай болж дээ. "Авиан зүй", "үгийн зүй", "өгүүлбэрийн зүй", "хэлний шинжлэл" гэж тусад нь бичдэг байснаа, цаана нь "фонетика буюу phonetics", "морфология буюу morphology", "синтаксис буюу syntax", "лингвистика буюу linguistics" гэсэн ганц ганц үг байгаа учраас "авиазүй", "үгзүй", "өгүүлбэрзүй", "хэлшинжлэл" гэж нийлүүлж бичнэ гэх боллоо. Ингэх нь буруу байхаа. Яагаад гэвэл, "рукопись буюу manuscript"-ийг "гарбичмэл", "абзац буюу paragraph"-ийг "доголмөр", "Монголия", "Россия" гэдэг үгсийг "Монголулс", "Оросулс" гэж бичихгүй нь лавтай.

Орчуулагч орос овог нэрүүдийг оросоор нь авсан нь зохиолын хамаг давс хужрыг усанд урсгачихав бололтой. Хүний нэрийг орчуулдаг юм уу гэсэн асуулт гарах нь мэдээж. Хүний нэр хүнийг нэрлэх төдий үүргээрээ л байгаа бол орчуулахгүй, харин үндсэн үүргийнхээ хажуугаар уран сайхны үүргийг давхар гүйцэтгэж байгаа бол орчуулахгүй байх аваас уг үүрэг алдагдана. Энэхүү өгүүллэгт зохиолч адууны нас, хүйс, үүлдэр угсаа, тоног хэрэглэлийн нэрээс хүний 40 гаруй нэр үүсгэн, тэдгээрт уран сайхны тодорхой үүрэг оногдуулж, өгүүллэгийн төгсгөлд "овьёос" гэдэг үгээс үүссэн "Овсов" гэдэг овгийг гарган ирж, ээдрээний учгийг тайлж байна. Чухам үүнд л зохиолын амт шимт нь нуугдаж байгаа билээ. Ийм ч учраас Кобылин, Жеребцов,

аа” гэж дуудсантай адил.

көрсеткіштерін анықтауға мүмкіндік береді.

¹⁶⁴ Комиссаров В.Н. Теория перевода (лингвистические аспекты). М., 1990, стр. 8.

Сүүлийн үед хүмүүс цагийн аясыг даган шүүмж бичихээ больжээ. Уг нь энэ мэт шүүмжлэлт санаа бодол хааяа ч гэлээ цухалзаж байх аваас орчуулга улам чамбайрч, орчуулагчийн хариуцлага дээшилж, улмаар эцэст нь уншигч олон түмний гарт чанартай сайн бүтээл очиж байхсан билээ. Шүүмж бичнэ гэдэг бол хүний мууг үзэх, өөрийн мэдлэг чадварыг дөвийлгөх гэсэн хэрэг огтхон ч биш учраас олж анзаарсан зүйлээ зоригтой шүүмжлэн бичдэг, шүүмжлүүлсэн нь эмзэглэдэггүй тийм уур амьсгалыг манай утга зохиолд эгүүлэн авчрах цаг болсныг дашрамд тэмдэглэе.

Залуу орчуулагчдад хандан хэлэхэд, эх хэлээрээ уран яруу найруулан бичихийн зэрэгцээ орчуулж буй зүйлийнхээ нарийн ширийн утгыг сайтар ухан ойлгохгүй, энэ мэт алдаа мадаг гаргах нь зохиолчийн хэлэх гэсэн санааг гуйвуулах, тэс өөр утгатай болгох, уран сайхны дүр дүрслэлийг бүдгэрүүлэх, улмаар давс хужрыг нь тунгаан гаргаж чадахгүйд хүргэх осолтойг бодууштай. Гэхдээ энэ мэт зүйлээс айж эмээлгүй зориглон орчуулж, бусад ард түмний оюуны соёлын охь манлайгаас монгол уншигчиддаа дээжлэн хүртээсээр байх нь зөв зүйтэй, буянтай ажил мөнөөс мөн. Молхи мань мэт нь өөрөө орчуулж гийгүүлэхгүй мөртлөө элдэв юм бичиж гоочилбол гоочилж л байг, огтхон ч үл тоон улам чамбайрсугай. Яс сайт яван чангарна гэдэг билээ.

Ашигласан ном зохиол

1. Дамдинсүрэн Ц. Монгол хэл бичгийн тухай. Улаанбаатар, 1957. 10-р тал.
2. Комиссаров В.Н. Теория перевода (лингвистические аспекты). М., 1990, стр. 8.